

БАТЛАВ.
ЦССҮТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

Огноо: 2021.03.04

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД
ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛ ЗАЙЛУУЛАЛТ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ,
ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОДИС МАТЕРИАЛ, ХОГ ХАЯГДЛЫН УУТ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын дугаар: ЦССҮТ/202101001-03

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.03.04

ЦССҮТ-Д ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ, ЗАЙЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ЦССҮТ/202101001-03

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ЦССҮТ-Д ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ, ЗАЙЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

1. *Багц1: Энгийн хог хаягдлын уут нийлүүлэх - 1,191,200 төгрөг*
2. *Багц2: Аюултай хог хаягдлын уут нийлүүлэх - 1,692,000 төгрөг*
3. *Багц3: Аюулгүйн хайрцагны захиалга - 520,500 төгрөг*
4. *Багц4: Ариун цэврийн цаас, сальфетик нийлүүлэх- 4,887,500 төгрөг*
5. *Багц5: Цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэгдэх зүйлс нийлүүлэх - 5,951,700 төгрөг*
6. *Багц7: Аюултай хог хаягдал ачилт - 6,000,000 төгрөг*
7. *Багц8: Энгийн хог хаягдал ачилт - 960,000*

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно. Үнийн санал авах жишиг баримт бичгийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/tender.gov.mn/ сайтаас авна уу.

Үнийн саналыг 2021 оны 03 -р сарын 15-ны өдрийн 10 цаг 00 минут-с өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn-д** ирүүлнэ үү. Үнийн саналыг нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 03 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 40 минутад хурлын танхимд нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 3-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө-49, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн
хашаан дотор Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвийн
төв байр, 410 тоот
Утас: 88809996, 70112857
Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтаас**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (a) *Үнийн санал;*
 - (б) *Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;*
 - (в) *Чадварын мэдээлэл*
 - ✓ *2020 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт*
 - ✓ *Туршлагын мэдээлэл, 2020 онд гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар 2-с доошгүй*
 - ✓ *Ижил төстэй ажил үйлчилгээ гүйцэтгэсэн харилцагч байгууллагын тодорхойлолт 2-с доошгүй*
 - ✓ *Нийгмийн даатгалын ерөнхий газрын тодорхойлолт*
 - ✓ *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт*
 - ✓ *Татварын албаны тодорхойлолт*
 - ✓ *Харилцагч банкны тодорхойлолт*
 - (г) *Баац7: Шаардлагатай тусгай зөвшөөрөл*
 - (д) *Улсын бүртгэлийн гэрчилгээ /хугацаа дуусаагүй байх/*
 - (е). *Гүйцэтгэлийн үйлчилгээг үзүүлэгч нь мэргэжлийн үнэмлэхтэй, үйлчилгээнийхээ талаар бүрэн мэдээллийг өгөх чадвартай, урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх бүрэн чадвартай, мэргэжлийн хүн байх ба мэргэжлийн үнэмлэхний хуулбар*
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан

бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

- | | |
|--|---|
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
<ul style="list-style-type: none"> • ТӨӨЗ 1.1 	<p><i>Үнийн санал;</i> <i>Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;</i> <i>Чадварын мэдээлэл</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>2020 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт</i> • <i>Туршлагын мэдээлэл, 2020 онд гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар 2-с доошгүй</i> • <i>Ижил төстэй ажил үйлчилгээ гүйцэтгэсэн харилцагч байгууллагын тодорхойлт 2-с доошгүй</i> • <i>Нийгмийн даатгалын ерөнхий газрын тодорхойлолт</i> • <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт</i> • <i>Татварын албаны тодорхойлолт</i> • <i>Харилцагч банкны тодорхойлолт</i> <p><i>Багц7: Шаардлагатай тусгай зөвшөөрөл</i> <i>Улсын бүртгэлийн гэрчилгээ /хугацаа дуусаагүй байх/</i> <i>Гүйцэтгэлийн үйлчилгээг үзүүлэгч нь мэргэжлийн үнэмлэхтэй, үйлчилгээнийхээ талаар бүрэн мэдээллийг өгөх чадвартай, урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх бүрэн чадвартай, мэргэжлийн хүн байх ба мэргэжлийн үнэмлэхний хуулбар</i></p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтад цахимаар, хялбаршуулсан цахим Огноо: 2021 оны 03 сарын 15-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв БЗД 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-49, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хойно Давхар болон өрөөний дугаар: 4 давхар, Хурлын танхим Огноо: 2021 оны 03 сарын 15-ны өдөр Цаг: 10 цаг 40 минут</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендер оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын талаар бичсэн танилцуулга 2. Нийлүүлэх барааны фото зураг, танилцуулга
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц: 1 Энгийн хог хаягдлын уут нийлүүлэх- 1,191,200 төгрөг Багц: 2 Аюултай хог хаягдлын уут нийлүүлэх -1,692,000 төгрөг Багц: 3 Аюулгүйн хайрцаг нийлүүлэх -520,500 төгрөг Багц: 4 Ариун цэврийн цаас, сальфетик нийлүүлэх- 4,887,500 төгрөг Багц: 5 Цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэгдэх зүйлс нийлүүлэх - 5,951,700 төгрөг Багц: 7 Аюултай хог хаягдал ачилт – 6,000,000 төгрөг Багц: 8 Энгийн хог хаягдал ачилт – 960,000 төгрөг</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 1. Энгийн хог хаягдлын уут нийлүүлэх

№	Бүтээгдэхүүний нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Шаардагдаж буй хэмжээ тоо	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						03 сар	09 сар	Нийлүүлэгчээс санал болгосон
1.	Хог хаягдлын хар уут	Хар өнгөтэй, 60x50 /урт*өргөн/ хэмжээтэй, шингэн нэвчдэггүй, бат бөх, биоаюулгүйн таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг уутны гадна талд байрлуулсан байх стандартын шаардлага хангасан байх	ширхэг	11,000	Цус сэлбэлт судлалын үндэсний төв, агуулах	8000ш	3000ш	
2.		Хар өнгөтэй, 80x60 /80*30*14,5/ хэмжээтэй, 2,5 микрон зузаантай, шингэн нэвчдэггүй, бат бөх, стандартын шаардлага хангасан байх	Боодол 30 ширхэг	100		70 боодол	30 боодол	

Багц 2. Аюултай хог хаягдлын уут нийлүүлэх

№	Бүтээгдэхүүний нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Шаардагдаж буй хэмжээ тоо	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						03 сар	09 сар	Нийлүүлэгчээс санал болгосон
1.	Хог хаягдлын шар уут	Шар өнгөтэй, 60x50 /урт*өргөн/ хэмжээтэй, амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдэггүй, бат бөх, биоаюулгүйн таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг уутны гадна талд байрлуулсан байх, нийлэг материалаар хийгдсэн, 7 микроноос багагүй зузаантай уут байх, стандартын шаардлага хангасан байх	ширхэг	9000	Цус сэлбэлт судлалын үндэсний төв, агуулах	7000ш	2000ш	

2.	Хог хаягдлын хүрэн уут	Хүрэн өнгөтэй, 60x50 /урт*өргөн/ хэмжээтэй, амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдэггүй, бат бөх, биоаюулгүйн таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг уутны гадна талд байрлуулсан байх, нийлэг материалаар хийгдсэн, 7 микроноос багагүй зузаантай уут байх, стандартын шаардлага хангасан байх	ширхэг	400		300ш	100ш	
----	------------------------	---	--------	-----	--	------	------	--

Багц 3. Аюулгүйн хайрцаг нийлүүлэх

№	Бүтээгдэхүүний нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Шаардагдаж буй хэмжээ тоо	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						03 сар	09 сар	Нийлүүлэгчээс санал болгосон
1	Аюулгүй хайрцаг	Халдвартай хурц үзүүртэй зүү устгах зориулалттай, биоаюулгүйн тэмдэглэгээтэй шингэн нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, зориулалтын зузаан цаасан, ЭНЭ ТҮВШНЭЭС ХЭТРҮҮЛЭН ДҮҮРГЭХИЙГ ХОРИГЛОНО” гэсэн анхааруулга бүхий хэвтээ шугам аюулгүйн хайрцагны гадна талын 3/4 хэсэгт хэвлэгдсэн байх шаардлагатай.	5литр	370	Цус сэлбэлт судлалын үндэсний төв, агуулах	250	120	
2			2литр	90		70	20	

Багц 4. Ариун цэврийн цаас, сальфетик нийлүүлэх

№	Нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Савлагаа	Тоо хэмжээ	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			
							03 сар	06 сар	09 сар	Нийлүүлэгчээс санал болгосон
1	Гарын цаасан сальфетик	Ус маш сайн шингээдэг, гарт наалдахгүй алчуур болгон ашиглах боломжтой зузаан сальфетик. Гар цаас нь хайрцганд хийж сугалж татах боломжтой, жин том нь 345 гр-аас багагүй жинтэй байна. Ахуйн сальфетик нь рулонтой тасалж хэрэглэх зориулалттай 30 см-ээс багагүй өндөртэй байна. Стандартын шаардлага хангасан байх	ш	100ш	550	Цус сэлбэлт судлалын үндэсний төв, агуулах	250ш	150ш	150ш	
2	Ахуйн сальфетик	Нягт: гр/м2= 32-50 нягтрал сайтай, ус сайн даадаг Ороомгийн урт: 50 м Цаасны өргөн: 9 см Ариун цэврийн цаас нь цаасны жингээс хамааран 1 буюу 2 давхар цаасаар хийгдсэн байна. Дамарын голын диаметр нь 9,5см-аас ихгүй байх бөгөөд нийт цаасан ороомгийн зузаан нь 7см-с багагүй байна. 50м урттай, гадуураа тусгаарлагч цаастай байна. Стандартын шаардлага хангасан байх	ш	150ш	100		50ш	50ш	-	
3	Ариун цэврийн цаас	Нягт: гр/м2= 32-50 нягтрал сайтай, ус сайн даадаг Ороомгийн урт: 50 м Цаасны өргөн: 9 см Ариун цэврийн цаас нь цаасны жингээс хамааран 1 буюу 2 давхар цаасаар хийгдсэн байна. Дамарын голын диаметр нь 9,5см-аас ихгүй байх бөгөөд нийт цаасан ороомгийн зузаан нь 7см-с багагүй байна. 50м урттай, гадуураа тусгаарлагч цаастай байна. Стандартын шаардлага хангасан байх	ш	Том	750		250ш	250ш	250ш	

Багц 5. Цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэгдэх зүйлс нийлүүлэх

№	Нэр	Тодорхойлолт	Хэм жиж нэгж	Савлагаа	Тоо хэмжээ	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			
							03 сар	06 сар	09 сар	Нийлүүлэгчээс санал болгосон
1	Гарын шингэн саван	Бактерийн эсрэг үйлчилгээтэй, Гар хуурайшуулж эмзэгшүүлэхгүй	ш	20л	5	Цус сэлбэлт судлалын үндэсний төв, агуулах	3	2	-	
2	Угаалгын нунтаг	Гар хуурайшуулж эмзэгшүүлэхгүй, цайруулагчтай, хөөсрөлт сайтай, хэцүү хир толбыг маш сайн цэвэрлэдэг. Угаалгын машинаар болон гараар угаахад тохиромжтой.	кг	1кг	251		100	100	51	
3	Хувцас цайруулагч	Ариутгах, цэвэрлэх, цайруулах үйлчилгээтэй	ш	1л	24		14	10	-	
4	Гадаргуу цэвэрлэгч	Бактерийг 99,99% устагддаг нунтаг бүх төрлийн гадаргууг цэвэрлэдэг.	ш	475гр	83		40	22	21	
5	Шил арчигч	Шүршиж хэрэглэдэг байх, шилэн гадаргууг загалтуулдаггүй.	ш	500мл	84		40	22	22	
6	Суултуур цэвэрлэгч	Бактерийг 99,99% устгаж халдваргүйжүүлнэ.	ш	500гр	40		15	15	10	
7	Ахуйн бээлий	Сайн чанарын ахуйн хэрэглээний бээлий,	ш	-	200		100	100	-	

		мөөгөнцөр ба нян үржихээс сэргийлсэн, халдваргүйжүүлэлтийн бодист тэсвэр сайтай. Зузаан ризенин материалтай							
8	Эдийн саван	Хатуу шахмал хэлбэртэй, хөөсрөлт сайтай хэр толбыг маш сайн цэвэрлэдэг	ш	246гр	350	150	100	100	
9	Илгэн алчуур	Ус шингээх чанар хамгийн өндөртэй байх, энгийн алчууртай харьцуулахад 3-5 дахин удаан эдэлгээтэй. Маш зөөлөн бөгөөд өндөр нягтшилтэй агшиж, сунадаггүй байх, 50*50 см хэмжээтэй	ш	-	40	20	20	-	
10	Шалны алчуур	Ус шингээх чанар хамгийн өндөртэй байх	ш	-	100	100	-	-	
11	Тоосны 3 өнгийн алчуур /ногоон, шар,ягаан/	Ус шингээх чанар хамгийн өндөртэй. Гадаргууг толбо үлдээж загалтуулахгүй, хог татдаггүй материалтай	Уут	-	140	140	-	-	
12	Мебель өнгөлөгч	Мебелийг цэвэрлэж гялалзуулах ба толбо үлдээхгүй. Гадаргуун өнгийг маш сайн сэргээж өнгөлдөг. Тоос, хурууны хээ, толбыг хялбар	ш	250гр	15	15	-	-	

		арилгадаг.							
13	Паркет өнгөлөгч	Бүх төрлийн модон, паркетан, ламинантан шаланд тохиромжтой Гадаргууг маш сайн өнгийг сэргээж өнгөлдөг загалтуулахгүй	ш	750гр	15		15	-	-
14	Аяга, таваг угаагч	Харшил өгөхгүй, тос маш сайн задалдаг	ш	500гр	36		26	10	-
15	Шүүр, хутгуур	Бат бөх материалтай. Шүүрний үс нь өтгөн зөөлөн	ш	-	7		7	-	-
16	Шалны мод	Хөндлөн хэсгийн урт нь 50 см ишний урт 130см-с багагүй хэмжээтэй зүлгүүр сайтай лакдсан байна.	ш	-	7		7	-	-
17	Агааржуулагч	Нүүрсхүчлийн хлорфтор агуулаагүй орчиндоо болон хүний эрүүл мэндэд аюулгүй, Шүршиж хэрэглэх зориулалттай	ш	300мл	100		50	50	-
18	А даавуу	Арчих материал /50 см өргөнтэй 200гр жинтэй/	Мет р	-	200		200	-	-

Багц 7. Аюултай хог ачилт

№	Нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Савлагаа	Тоо хэмжээ	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа
1	Аюултай хог хаягдал ачилт	Аюултай хог хаягдалын менежментийг дагаж мөрдөх Цус цуглуулах төвийн 2 байр	Улирал	-	4	7 хоног бүрийн 1, 3, 5 дахь өдөр

Багц 8. Энгийн хог хаягдал ачилт

№	Нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Савлагаа	Тоо хэмжээ	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа
1	Энгийн хог хаягдал ачилт	Хог хаягдалын менежментийг дагаж мөрдөх Цус цуглуулах төвийн 2 байр	Улирал	-	4	7 хоног бүрийн 2, 5 дахь өдөр

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Техникийн тодорхойлолтонд заасан шаардлагыг нэг бүрчлэн хангасан байх, шаардлага хангаагүй бараа, үйлчилгээг хүлээн авахгүй |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Хуваарийн дагуу үйлчилгээг үзүүлнэ. Үйлдвэрийн доголдлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Урьдчилгаа төлбөр олгохгүй.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: 0.05%</p> <p>Алдангийн нийт дүн: [0]</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг ____ оны __ дугаар сарын ____ -наас ____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.